

2018 ОНЫ ЭХНИЙ 9 САРД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ТАНИЛЦУУЛГА

2018.10.03

Улаанбаатар хот

Нэг.ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ

Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 55994-г хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын тоо нь өнгөрсөн оны үзүүлэлтээс улсын хэмжээнд 17.2 хувиар, Улаанбаатар хотод 16.8 хувиар тус тус статистик мэдээгээр буурсан үзүүлэлт гарч байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА



Зам тээврийн ослын дуудлагын 96.1 хувь нь нийслэлд ирүүлсэн дуудлага мэдээлэл, 3.9 хувь нь орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст ирүүлсэн дуудлага мэдээлэл эзэлсэн байна. Улсын хэмжээнд 21346 зам тээврийн осол бүртгэгдсэний 19191 буюу 89.9 хувь нь нийслэлд, 10.1 хувь нь орон нутгийн замд бүртгэгджээ. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад нийслэлд осол 23.7 хувиар, орон нутагт 25.3 хувиар тус тус буурчээ.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ



Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад: зам тээврийн осол улсын хэмжээнд буурсан ч Булган, Хөвсгөл аймгуудад 2 дахин, Хэнтий аймагт 8 дахин, Дундговь аймагт 34.9 хувь, Өмнөговь аймагт 68.9 хувиар өссөн үзүүлэлт гарсан. Говь-Сүмбэр, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ зэрэг аймгуудад 86.7-53.6 хувиар зам тээврийн осол буурсан байна.

Хоёр. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2018 оны 9 сарын байдлаар нийт 28550 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 997 буюу 3.5 хувийг эзэлж байна. /хувийн жин 0,5 хувиар өссөн/



Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн зүйл заалтаар авсан бүртгэлээс харахад: Авто замд бүртгэгдсэн гэмт хэрэг 991, Төмөр замын бүсэд 6, Иргэний агаарын тээврийн бүсэд 1 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд 23.2, нийслэлд 30.8, орон нутагт 16.7 хувиар тус тус буурчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 245 хүн нас барж, 696 хүн гэмтсэн статистик үзүүлэлт гарсан ч бодит нас баралт 420-д хүрсэн.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 42.2 хувь нь нийслэлд, 57.8 хувь нь орон нутагт бүртгэгджээ. Гэмт хэрэг Арханайгай аймагт 7.1%, Дорнод Говь-Алтай аймагт 40.0%, Дархан-Уул аймагт 19.4%, Дорнод аймагт 21.9%, Увс аймагт 27.3%, Налайх дүүрэг 26.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй. Бусад аймаг болон нийслэлийн дүүргүүдэд 10.4-69.6 хувийн бууралттай байна.

Гурав. ТӨМӨР ЗАМЫН БҮСЭД ГАРСАН ГЭМТ ХЭРЭГ

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих /ЭХ 27.1-27.3/ заалтаар 2018 оны эхний 9 сарын байдлаар 13 гэмт хэрэг үүсгэгдэн шалгагдаж 8 хэрэг хэрэгсэхгүй болж мэдээнээс хасагдаж тооцогдсон байна.



Энэ төрлийн гэмт хэрэг өнгөрсөн онтой харьцуулахад 14.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Агаарын тээврийн аюулгүй байдалд халдах төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.





Дөрөв. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 420 хүн нас барж /бодит нас баралтын тоо/, 3557 хүн гэмтэж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 13,5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 245 хүн нас барж, 692 хүн гэмтсэн байна.



ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС НАС БАРСАН ХҮН:



Хүний амь нас хохирсон зам тээврийн осол 374 бүртгэгдэж 420 хүний амь нас хохирчээ. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад хүний амь нас хохирсон ослын тохиолдол 12.0 хувиар, амь насаа алдсан хүний тоо 7.1 хувиар өсчээ. Амь насаа алдсан хүний 74.8 хувь нь орон нутагт, 25.2 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.



Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон 148 хэрэг ЭХХШТХуулийн 1.5.1.1 /32.5.1.1/ дэх заалтаар хэрэгсэхгүй болж статистик мэдээнээс хасагдсан учир улсын хэмжээний гэмт хэргийн мэдээнд нас барсан хүний тоо 245 хүнээр тусгагдсан байна.



Нийслэлийн хэмжээнд 2018 оны эхний 9 сарын байдлаар зам тээврийн ослын улмаас 106 /бодит/, гэмт хэргийн улмаас 81 хүн амь насаа алдсан үзүүлэлт гарч байна.




Хүний амь нас хохирсон 90 ослын улмаас 106 хүний амь нас хохирсон нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 8.4 хувиар, 106 хүн зам тээврийн ослын улмаас нас барсан нь 21.8 хувиар, 81 хүн гэмт хэргийн улмаас нас барсан нь 19.1 хувиар тус тус өсчээ.

Хүн нас барсан үзүүлэлт Налайх дүүрэг 6.5 дахин, Хан-Уул дүүрэг 80.0 хувийн, Баянзүрх дүүрэг 26.7 хувийн өсөлттэй байгаа нь нийслэлийн хэмжээнд зам тээврийн ослын улмаас нас баралт өсөхөд нөлөөлсөн байна.


Зам тээврийн ослын нас баралт Баянгол дүүрэгт 40.0 хувийн, Сонгинохайрхан дүүрэгт 6.1 хувийн бууралттай байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН ХҮН:


Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 3557 хүн эрүүл мэндээрээ хохирсоны 696 нь хүнд, хүндэвтэр зэргийн гэмтэл, 2861 нь хөнгөн зэргийн буюу тодорхой хэмжээний гэмтэл, бэртэл авсан.



Гэмт хэргийн улмаас 331 буюу 47.6 хувь нь нийслэлд, 365 буюу 52.4 хувь нь орон нутагт хүнд, хүндэвтэр гэмтэж хохирсон байна.





Зам тээврийн ослын улмаас 1796 буюу 78.8 хувь нь нийслэлд үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас, 21.2 хувь нь орон нутгийн замд үйлдэгдсэн ослын улмаас гэмтэл, бэртэл авсан байна.



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 420 хүн /бодит/, гэмтсэн 3557 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:


Улсын хэмжээнд:

- Явган зорчигч – 90 хүн амь насаа алдаж, 1764 гэмтсэн
- **Жолооч** – 172 хүн амь насаа алдаж, 553 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 157 хүн амь насаа алдаж, 1141 гэмтсэн
- Дугуйтай хүн – 1 нас барж, 99 гэмтсэн




Улаанбаатар хотод:

- **Явган зорчигч** – 51 хүн амь насаа алдаж, 1609 гэмтсэн
- Жолооч – 17 хүн амь насаа алдаж, 347 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 38 хүн амь насаа алдаж, 663 гэмтсэн
- Дугуйтай хүн – 98 гэмтсэн



Орон нутагт:

- Явган зорчигч – 39 хүн амь насаа алдаж, 155 гэмтсэн
- **Жолооч** – 155 хүн амь насаа алдаж, 206 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр **зорчигч** – 119 хүн амь насаа алдаж, 478 гэмтсэн
- Дугуйтай хүн – 1 нас барж, 1 гэмтсэн




Амь насаа алдсан хүний замын хөдөлгөөнд оролцсон хэлбэрээс харахад орон нутагт **ЖОЛООЧ**, тээврийн хэрэгслээр **ЗОРЧИГЧ** амь насаа алдсан үзүүлэлт их, нийслэлд **ЯВГАН ЗОРЧИГЧ** гэмтэж, бэртэж байгааг дээрх тоон үзүүлэлтүүдээс харж болно.

Тав. **ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРСОН ОСОЛ** /Гэмт хэрэг/


Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон осол /хэрэг/ 374 бүртгэгдэж 420 хүн нас барсан байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад хүний амь нас хохирсон осол 12.0 хувиар, нас барсан хүний тоо 7.1 хувиар тус тус өсчээ. Хүн нас барсан осол орон нутгийн замд 284 буюу 77.0 хувь, нийслэлд 90 буюу 23.0 хувь нь бүртгэгджээ.



Улсын хэмжээнд 2 ба түүнээс дээш хүний амь нас хохирсон осол 56 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 24.4 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.



2018 оны эхний 9 сарын байдлаар 420 хүн нас барсан байдлыг сараар гаргасан бүртгэлээс харахад 8-9 саруудад ихэссэн байна. Өмнөх жилүүдийн үзүүлэлтээс харж байхад зуны дулаан цаг, амралт, зугаалгын үе болох 6-8 саруудад хүний амь нас хохирсон осол орон нутгийн замд их бүртгэгдсэн.



Хүний амь нас хохирсон осол 06.00-14.00 цагт 110 буюу 29.4 хувь, 14.00-19.00 цагуудад 121 буюу 32.4 хувь, 19.00-22.00 цагуудад 71 буюу 19.0 хувь, 22.00-06.00 цагуудад 72 буюу 19.3 хувь нь тус тус бүртгэгджээ.

Хүний амь нас хохирсон 374 ослын /хэрэг/ шалтгаан нөхцлийн байдлаас авч үзвэл:



Анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан осол нийт ослын 29.9 хувийг, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 25.9 хувийг, хурд хэтрүүлэн явсан 18.4 хувийг, тус тус эзэлжээ.




Тухайн осол гарсан хэлбэрээс авч үзвэл: 174 буюу 46.5 хувь нь онхолдох, 88 буюу 23.5 хувь нь мөргөлдөх, 94 буюу 25.1 хувь нь явган зорчигч мөргөх, зорчигч хэлбэрээр тус тус гарчээ.

Хүний амь нас хохирсон ослын шалтгаан нөхцлөөс үзвэл: Орон нутгийн замд онхолдох хэлбэрээр өдрийн цагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, хурд хэтрүүлсэн, анхаарал болгоомжгүйгээс гарсан ослын улмаас хүний амь нас ихээхэн хохирсон байна.

Зургаа. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 21346 зам тээврийн ослын 20858 буюу 97.7 хувь нь жолоочийн буруугаас, 453 буюу 2.1 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 35 буюу 0.2 хувь нь бүртгэгджээ.




№	ШАЛТГААН	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Жолоочийн буруутай үйлдэл	20858	97.7	18786	97.9	2072	96.1
2	Явган зорчигчийн буруутай үйлдэл	453	2.1	385	2.0	68	3.2
3	Замын нөхцөл	35	0.2	20	0.1	15	0.7

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 97.7 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ба хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл, хурд хэтрүүлсэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол дийлэнх хувийг эзэлсэн.




Зам тээврийн ослын шалтгаан дотроос хамгийн их хор уршиг учруулдаг шалтгаан нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх тохиолдол байдаг. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 8.1 хувиар, хурд хэтрүүлсэнээс үйлдэгдсэн осол 2.1 дахин өссөн үзүүлэлт гарч байна.



Хурд хэтрүүлсэн осол Өмнөговь, Төв, Хэнтий аймгуудад давамгайлсан байхад нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан Чингэлтэй, дүүрэгт их бүртгэгдсэн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын хувьд улсын хэмжээнд 453 бүртгэгдсэн нь нийт ослын 2.1 хувийг эзэлсэн байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 84.9 хувь нь нийслэлд бүртгэгджээ.



Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 165 буюу 36.4 хувийг явган зорчигчийн өөрийн буруу, 75 буюу 16.6 хувийг эцэг, эх, асран хамгаалагчийн буруутай үйлдэл, 213 буюу 47.0 хувь нь явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан байна. Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос зам тээврийн осолд өртөх нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 3.6 хувиар буурсан боловч нийслэлд

явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцох нь дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна.

Долоо. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 21346 зам тээврийн ослын 18139 буюу 85.0 хувь нь мөргөлдөх, 1829 буюу 8.6 хувь нь явган зорчигч мөргөх, 651 буюу 3.0 хувь нь онхолдох, 466 буюу 2.2 хувь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, орон сууц, шон мөргөсөн/, зорчигч унагах 10 осол, дугуйтай хүн мөргөх 110 осол, мал, амьтан дайрах 59 осол, 82 буюу 0.4 хувь нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.



Орон нутагт тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, онхолдох хэлбэрээр гарсан осол дийлэнх хувийг эзэлсэн байхад нийслэлд тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, тээврийн хэрэгслээр явган зорчигч мөргөх хэлбэрээр гарсан осол их бүртгэгдсэн байна.


№	ХЭЛБЭР	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Мөргөлдөх	18139	85.0	16982	88.5	1157	53.7
2	Явган хүн дайрах	1829	8.6	1609	8.4	220	10.2
3	Үл хөдлөх зүйл мөргөх	466	2.2	349	1.8	117	5.4
4	Онхолдох	651	3.0	110	0.6	541	25.1
5	Мал, амьтан дайрах	59	0.3	21	0.1	38	1.8
6	Зорчигч унагах	10	0.05	2	0.01	8	0.4
7	Дугуйтай хүн мөргөх	110	0.5	97	0.5	13	0.6
8	Бусад	82	0.4	21	0.1	61	2.8

Зургаа. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ГАРАГ, ЦАГ ХУГАЦАА

Осол гарсан цагийн бүртгэлээс харвал:

- 06.00-14.00 цагийн хооронд 5692 буюу 26.7 хувь,
- 14.00-19.00 цагийн хооронд 6402 буюу 30.0 хувь,
- 19.00-22.00 цагийн хооронд 5516 буюу 25.8 хувь,
- 22.00-06.00 цагийн хооронд 3736 буюу 17.5 хувь нь тус тус бүртгэгджээ.

Осол их бүртгэгдэж байгаа цагийн байдлаас харахад 14.00-19.00 цагуудад осол их гарсан байна.




Зам тээврийн осол гарсан гаригаас харахад: Даваа гарагт 15.1 хувь, мягмар гарагт 14.6%, лхагва гарагт 15.4 хувь, пүрэвт гарагт 14.6 хувь, баасан гарагт 15.4 хувь, бямба гарагт 13.0 хувь, ням гарагт 11.9 хувь нь бүртгэгдсэн байна.

Найм. ХҮҮХЭД ӨРТСӨН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ


2018 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 692 бүртгэгдэж ослын улмаас 31 хүүхэд амь насаа алдаж, 467 хүүхэд гэмтэл авснаас 111 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авч, эрүүл мэндээрээ ноцтой хохирчээ. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад хүүхэд өртсөн ослын гаралт 20.1 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 26.0 хувиар, нас барсан хүүхэд 41.5 хувиар тус тус буурсан.




Хүүхэд өртсөн зам тээврийн ослын 82.2 хувь нь нийслэл хотод, амь насаа алдсан хүүхдийн 74,1 хувь, гэмтсэн хүүхдийн 54.9 хувь нь орон нутагт бүртгэгджээ.



Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний 11.0 хувийг хүүхдийн нас баралт, гэмтсэн хүний 14.0 хувийг гэмтэл авсан хүүхэд эзэлжээ.



Улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоон үзүүлэлтээс харахад: 490 явган зорчигч, 197 тээврийн хэрэгслээр зорчигч, 57 унадаг дугуйгаар зорчигч хүүхэд амь нас, эрүүл мэндээрээ хохирсон.



Нийслэлд явганаар замын хөдөлгөөнд оролцож осолд өртсөн 10 хүртэл насны хүүхдийн 23,5 хувь нь насанд хүрсэн харгалзах хүнтэй замын хөдөлгөөнд оролцсон бол 49.9 хувь нь харгалзах хүнгүй ганцаараа, 26.5 хувь нь насанд хүрээгүй найз, ах, эгч дүү нартайгаа замын хөдөлгөөнд оролцсон байна.

Ёс. ДҮГНЭЛТ

2018 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага, бүртгэгдсэн зам тээврийн осол, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хүүхэд өртсөн ослын гаралт буурсан байна. “Орон нутгийн замын хөдөлгөөний соёл 2018” нэгдсэн арга хэмжээ 2018 оны 06 дугаар сараас эхлэн явагдсантай холбоотой 6-9 саруудад орон нутагт гарсан хэрэг, нас баралт, гэмтсэн хүний үзүүлэлт 9.6-24.0 хувиар буурсан нь орон нутгийн замд хяналт, шалгалт эрчимжсэнтэй холбон үзэж байна.

Зам тээврийн осол, хэрэг буурсан хэдий ч хүний амь нас хохирсон ослын гаралт 12.0 хувиар, бодит нас баралт 7.1 хувиар, ослын улмаас иргэн, аж ахуйн нэгжид учирсан эд

материалын хохирол 4.1 дахин өссөн, хүний амь нас хохирсон ослын 75.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн, хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон осол 24.4 хувиар өссөн зэрэг үзүүлэлтүүдээс харахад хүний амь нас хохирсон, ноцтой ослын гаралт буурахгүй байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд 2018 оны эхний 9 сард бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцлөөс харахад жолоочийн буруутай үйлдлээс 97.7 хувь нь бүртгэгдэж, жолоочийн буруутай үйлдэл дотроо хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн, хурд хэтрүүлсэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнээс гарсан осол дийлэнх хувийг эзэлсэн байна. Хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан осол 86.7 хувиар, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнээс шалтгаалсан осол 3.2 хувиар, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан.

Хүний амь нас хохирсон ослын 25.9 хувийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос, 18.4 хувийг хурд хэтрүүлсэнээс, 46,5 хувь нь онхолдох хэлбэрээр гарчээ.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхэд эхний хагас жилийн байдлаар нийт нас барсан хүний 8.0 хувийг эзэлж байсан бол эхний 9 сарын байдлаар нийт нас барсан хүний 11.0 хувь болж хүүхдийн нас баралтийн хувийн жин 3.0 хувиар өссөн нь хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, орон нутгийн замд хүүхдийн тээвэрлэлт дээр анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослыг бууруулах /хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох/ арга хэмжээг оновтой авч хэрэгжүүлбэл улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирох явдлыг 44.3 хувь хүртэл бууруулах боломжтой юм.

Нийслэлд явган зорчигч замын хөдөлгөөнд оролцож байгаад амь насаа алдах нь их байх тул явган зорчигчийн замын аюулгүй байдал /тэмдэг тэмдэглэгээ, хаалт хашлага, нүхэн гарц, гэрэл дохионы зохицуулалт, замын гэрэлтүүлэг г.м/-д хяналт тавих чиглэлээр ажил зохион байгуулбал тодорхой хэмжээнд үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Зам тээврийн ослын нөхцөл, байдал, тоон үзүүлэлтээс харахад нийт замын хөдөлгөөнд оролцогч /жолооч, явган зорчигч, дугуйгаар зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигч/-дын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулахад анхаарал хандуулан энэ чиглэлийн ажил, арга хэмжээ зохион байгуулах, эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай болж байгааг харуулж байна.

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА